



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ**

Нам Ян Жугийн гудамж 32/1,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335  
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,  
Цахим шуудан: info@nccd.gov.mn,  
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2024.12.24 № 3-3/1525  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хамтран ажиллах тухай

Тус төвөөс Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн зардлын өртөг үр ашгийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгүүлэх гэж байгаа тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу үнийн саналыг 2024 оны 12-дугаар сарын 31-ны өдрийн дотор [tender@nccd.gov.mn](mailto:tender@nccd.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт 2 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.АНХБАЯР

Халдварт Өвчин Судлалын Үндэсний  
Төвийн 2024 оны 3-р дугаартай  
албан бичгийн хавсралт



**Нэр:** Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн зардлын өртөг үр ашгийн үнэлгээ

**Зорилго:** 2021-2023 онд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийг тодорхойлох, тулгамдаж буй бэрхшээл, асуудлыг тодорхойлох, зөвлөмж гаргах

**Эхлэх хугацаа:** 2023 оны 01 дугаар сарын 02 ны өдөр

**Дуусах хугацаа:** 2024 оны 03 дугаар сарын 31 ний өдөр

**Байршил:** Халдварт өвчин судлалын үндэсний төв

1	Зорилт	1. Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулахад гарсан санхүүжилтийг тооцох 2. Тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, зөвлөмжийг боловсруулах
2	Үндэслэл	2017 оноос эхлэн сүрьеэгийн тусламж үйлчилгээний журам, зааврын дагуу идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулж, илрүүлэлтийг нэмэгдүүлэхийг зорьж, хамгийн мэдрэг үзүүлэлттэй өндөр өртөг бүхий оношилгооны тоног төхөөрөмжүүдийг шат дараалалтайгаар нэвтрүүлж, аймаг дүүрэгт ханган нийлүүлсэн ч илрүүлэлтэд төдийлөн нөлөө үзүүлэхгүй, нийт бүртгэгдсэн тохиолдлын 10% орчим хувийг илрүүлсэн байна. Энэхүү үйл ажиллагаанд хөрөнгө мөнгийг зарцуулсан хэвээр байна. Иймд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн зарцуулалт, өртөг үр ашгийн үнэлгээг хийж цаашид ашигтай зардлын аргуудыг тодорхойлох шаардлагатай байна.
3	Хамрах хүрээ	Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон Глобал сан дэмжлэгтэй хийгдсэн сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт
4	Цар хүрээ	1. Үнэлгээний арга аргачлал боловсруулах 2. Үнэлгээний талбар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх 3. Үнэлгээний тайлан бичих 4. Үнэлгээний үр дүнг танилцуулах уулзалт зохион байгуулах 5. Үнэлгээний тайланг хэвлүүлэн, хүлээлгэн өгөх 6. Гэрээ дүгнэсэн акт үйлдэх, хүлээж авах 7. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

		боловсруулж хүлээлгэж өгөх
5	Үнэлгээ хийх байгууллагад тавигдах шаардлага	<p>Үнэлгээ, судалгаа, шинжилгээний ажил 8-аас доошгүй жил, эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай, байгууллагын чиг үүрэг, хүний нөөц, хууль тогтоомжид үнэлгээ, шинжилгээ хийх, санал дүгнэлт боловсруулах чадвартай судлаач бүхий төрийн болон төрийн бус байгууллага, сургалт эрдэм шинжилгээний байгууллага байх</p> <p>Өмнө нь ижил төрлийн үнэлгээ, хөтөлбөр боловсруулах ажил гүйцэтгэж байсныг давуу тал гэж үзнэ.</p>
6	Тайлангийн хуваарь	Гэрээ байгуулж ажил гүйцэтгэж эхэлсэн өдрөөс хойш хуанлийн 20 хоног тутамд ажлын явц үр дүнг тайлагнаж байна.
7	Хүлээгдэж буй үр дүн	Ажлын даалгаврын дагуу боловсруулсан тайлан, судалгааны материал, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хандсан зөвлөмжийн төсөл байна.
8	Гүйцэтгэх ажлын шаардлага	<p>Үнэлгээний эх нь Монгол хэл дээр бичигдсэн байна.</p> <p>Үнэлгээ нь агуулгын хувьд харилцан уялдаатай, иж бүрэн шинжлэх ухааны судалгааны тодорхой арга зүйд үндэслэсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн, онол практикийн ач холбогдол бүхий байна.</p> <p>Үнэлгээ / тайлан, төсөл, судалгаа, санал, зөвлөмж/-ний хэлбэржүүлэлт / формат/ нь төрийн албан хэрэг хөтлөлтийн журам, судалгааны ажилд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн, хэл зүйн болон утга найруулгын алдаагүй байна.</p>
9	Төлбөрийн нөхцөл	Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.
10	Санал ирүүлэх	Шалгаруулалтыг бага үнийн аргаар явуулна. Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлэн <a href="mailto:tender@nccd.gov.mn">tender@nccd.gov.mn</a> -ээр илрүүлнэ.